

НОГООН АЛТ ТӨСӨЛ (2013–2016)

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Ногоон алт төсөл

Төслийн хэрэгжих хугацаа:

2013-2016

ШХА-аас олгох санхүүжилт:

9,880,000 шв. франк

Зорилтот бүлэг:

75,000 малчин өрх

Зорилтот газар зүйн бүс:

Монгол орны баруун бүс, Завхан,
Увс, Ховд, Говь-Алтай, Байн-
Өлгий, Архангай, Баянхонгор
аймаг

ҮНДЭСЛЭЛ

Дөчин таван сая толгой малтай мал аж ахуйн салбар Монгол Улсын үндэсний эдийн засгийн тулгуур салбар юм. Улсын хэмжээнд нийт 140 мянга гаруй малчин өрх бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байна. Иймд бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх, малчдын бэлчээр ашиглах технологийн мэдлэгийг дээшлүүлэх, зах зээлд нэвтрэхэд нь дэмжих замаар малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд Ногоон алт төслийн зорилго чиглэгдэж байна.



Их Мянган БАХ-ны ахлагч С.Дүгэрсүрэн, Цагаанхайрхан сум, Завхан аймаг

ТӨСЛИЙН ҮР ДҮНГЭЭС:

2004 оноос хойш малчдын анхан шатны байгууллага болох бэлчээр ашиглагчдын бүлэг (БАХ)-үүдийг бэлчээрийн нөөцийг тогтвортой ашиглах, эдийн засгийн боломжийг сайжруулах чиглэлээр дэмжин ажиллаж ирлээ. 2014 оны байдлаар баруун бүсийн аймгуудын 96 суманд нийтдээ 53,000 малчин өрх буюу бүх малчин өрхийн 30 гаруй хувийг хамарсан 960 БАХ, малчдын 67 хоршоо байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Малчдын байгууллагын энэхүү системийг бэлчээрийн зохион байгуулалт, төлөвлөлтийг орон нутгийн түвшинд сайжруулах, малчдын оролцоог нэмэгдүүлэх чухал тогтолцоо хэмээн хүлээн зөвшөөрөх явдал Монгол Улсын Засгийн газрын түвшинд улам нэмэгдсээр байна.

■ 23 сумын 130-аад БАХ 5.1 сая га талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээжээ. Ургац, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор нийт 6,200 га хадлангийн талбай хашиж хамгааллаа. Малын тэжээлийн ургамал 80 га-д тариалж, малын бүтээгдэхүүн

(мах, сүү, арьс, ноос ноолуур)-ий жилийн борлуулалт 1.6 тэрбум төгрөгт хүрлээ.

- Сум, аймгийн иргэдийн Хуралд сонгогдсон малчид, БАХ-ийн тэргүүний тоо 2008 онд 42 байсан бол 2012 онд 266 болж өслөө.
- Улсын хэмжээний нийт 329 сумын 66-д нь Сумын бэлчээр ашиглагчдын холбоо (СБАХ), 21 аймгийн тавд нь Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо (АБАХ) байгуулагдаж малчдыг экстейншиний ба маркетингийн үйлчилгээгээр хангах чиг үүрэгтэй ажиллаж байна.
- Бэлчээрийн мониторингийн арга зүйг олон улсын стандартад нийцүүлэн шинэчиллээ.
- 66 суманд байгуулагдаад байгаа малчдын дундын сангаас 50,000 малчин өрх бэлэн мөнгөний хэрэгцээгээ хангаж, 16,783 малчин өрх орлого нэмэгдүүлэх төслийн санхүүгийн эх үүсвэр авч ашиглажээ.

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

ТӨСЛИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ

Малчдын амьжиргааг дээшлүүлэх, хөдөөгийн ядуурлыг бууруулах

Ногоон алт төсөл дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Бэлчээрийн тогтвортой менежмент, малчдын орлого нэмэгдүүлэх хамтын үйл ажиллагаа
- Хэрэглээний судалгаа
- Эрэлтэд суурилсан нэвтрүүлэх (экстеншн) үйлчилгээ
- Сарлагийн хөөвөр, тэмээний ноосны маркетинг зэрэг болно.

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН:

- **БАХ нь бэлчээрийн тогтвортой менежмент, эдийн засгийн хөгжлийг малчдын түвшинд хөхиүлэн дэмжих хамтын үйл ажиллагааны түшиц байгууллага болж бэхжинэ.** 2016 он гэхэд 126 суманд (бүх сумын 38 хувь) БАХ-ийн систем бүрдэж, тоо нь одоогийнхоос хоёр дахин нэмэгдэх бөгөөд хамрагдах малчин өрхийн тоо 75,000 орчимд хүрнэ.
- **ХАА-н хэрэглээний судалгаа нь бэлчээрийг экологийн чадавхид нь нийцүүлэн тогтвортой, бүтээмжтэй ашиглах, бэлчээрийн эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн мониторинг хэрэгжүүлэхэд Монгол Улсын үүрэг бүхий байгууллага, малчдад дэмжлэг үзүүлнэ.** Экологийн чадавхид суурилсан ашиглалтыг бэлчээрийн менежмент ба мониторингийн стандартын хэмжээнд мөрдүүлэхээр бүх түвшинд нэвтрүүлэхэд Ногоон алт төслөөс туслана. Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь мал аж ахуй, зэх зээл, бэлчээрийн менежментийн чиглэлээр эрэлтэд суурилсан судалгаа явуулж судалгааны үр дүн ба өгөөжтэй

арга ажиллагааг экстейншийн бэлэн зэхэц боловсруулах, туршиад ашиглах, цаашилбал үндэсний экстейншийн үйлчилгээгээр дамжуулан түгээнэ.

- **ХАА-н экстейншийн үйлчилгээгээр дамжуулан малчдад хэрэгтэй үйлчилгээ (мэдээлэл ба үйлчилгээ)-г хүргэнэ.** Эрэлтэд суурилсан экстейншийн үйлчилгээг малчдад үзүүлснээр МАА-г экологид ээлтэй, эдийн засгийн хувьд ашигтай хөгжлийн чиглэлд хандуулахад дэмжлэг болно. Экстейншийн ажилтнуудыг арга зүйд сургах, судалгаа, экстейншин ба малчдын хамтын байгууллагыг холбох, малчдад мэдээлэл хүргэх замаар экстейншийн үндэсний хөтөлбөрт туслалцаа үзүүлэх юм.
- **Тэмээний ноос, сарлагийн хөөврийн өртөг нэмэгдүүлэх боловсруулалт ба маркетингийн үйл ажиллагаа ядуу малчин өрхөд ихээхэн дэмжлэг болно.** Самнах, өнгөөр нь ангилал зэргээр сарлагийн ноолуур, тэмээний ноосны анхан шатны боловсруулалт хийх чиглэлээр малчдыг дадлагажуулах сургалт зохион байгуулна. Эдгээр арга ажиллагааны үр дүнд уг бүтээгдэхүүний зах зээлийн үнэ 2-3 дахин нэмэгдэнэ.

Хамтран хэрэгжүүлэх түншүүд:

- Бэлчээр ашиглагчдын аймгийн холбоо (Завхан, Увс, Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий, Архангай, Баянхонгор аймаг)
- ART (Agroscope Reckenholz-Tanikon судалгааны станц), USDA-ARS (US АНУ-ын ХАА-н департамент, ХАА-н судалгааны үйлчилгээ).
- Хөдөөгийн тогтвортой хөгжлийн холбоо, Монгол улс, Австралийн Queensland их сургууль
- ХБНГУ-ын зөвлөх компани GFA/GEFAK Консерцум

Холбоо барих:

Ногоон алт төслийн зохицуулах нэгж

Скай Плаза бизнес төв,
Олимпын гудамж 12, I хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

Утас: +976 11 326401
И-мэйл: info@greengold.mn
Вэб хуудас: www.greengold.mn

Монгол дахь Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар
Ш/Х 37, Улаанбаатар 210648,
Монгол улс

Утас: +976 11 331 422
Факс: +976 11 331 420
И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch
Вэб: www.swiss-cooperation.admin.ch



Баян-өлгий аймгийн Цэнгэл сум: 1000 га хадлангийн талбайн чулуун хашаа. 300 гаруй малчин өрх жил бүр 3000 тонн хадлан авч байна.